




Since 2015

**Brand** *Arte*  
MARKETING CONSULTING COMPANY




## БИД ТҮҮХ БҮТЭЭДЭГ

---

Брэндартэ компани нь 2015 онд байгуулагдсанаас хойш 80 гаруй компани, брэндийн 100 гаруй төсөл дээр маркетингийн зөвлөхөөр амжилттай ажиллаж зах зээлд тэсрэлт хийсэн олон брэндүүдийг бүтээж харилцагчдааса бизнесийн өсөлт, хөгжлийг бий болгожээ.

Бид бусдаас өвөрмөц байхыг эрмэлздэг брэндүүдтэй хамтран ажиллаж түүхэнд үлдэх амжилттай брэндүүдийг бүтээдэг.

---



## Бидэнд байнга шинэ санаа шийдэл байдаг

Бид харилцагчдадаа зах зээлд амжилттай ажиллах оновчтой шийдлийг зөвлөж бизнесийнх нь зорилго, зорилт, төслийн цар хүрээнээс шалтгаалан боломжит бага зардлаар өндөр үр дүнг бий болгон ажилладаг.

Бид мэргэжлийн мэдлэг туршлага, хүсэл сонирхолдоо хөтөлгөн Монголын болон үндэстэн дамнасан корпорацууд, шинээр төрөн гарсан болон өөрчлөгдөн шинэчлэгдсэн брэндүүд зэрэг гуч гаруй салбарын бүтээн байгуулагчидтай хамтран ажиллаж ирсэн.

Бид дотоодын зах зээл болон дэлхийн тавцанд нэрээ дуурьсгахаар зорьж буй бизнес эрхлэгчдийн стратегийн болон мэргэжлийн түнш нь байж, хамтдаа ТҮҮХ бүтээхээр зорьж буйгаараа бахархдаг.

**We Do  
DISRUPTIVE &  
INNOVATIVE  
Marketing**



БРЭНД ҮЙЛДВЭРТ  
БИШ ОЮУН САНААНД  
БИЙ БОЛДОГ

01

Бид ажилдаа  
дуртай, салбартаа  
эксперт

02

Бид эргэлздэг  
эргэцүүлдэг  
эрэлхийлдэг

03

Бид зах зээлийн  
чиг хандлагыг  
дагаж биш мэдэрч  
эхлүүлдэг

04

Бид хурдтай,  
хариуцлагатай

05

Бидэнд байнга  
шинэ санаа  
шийдэл байдаг

06

Бид Монголын зах  
зээл, хэрэглэгчийг  
мэддэг

07

Бид нөхцөл  
байдлыг зөв  
үнэлж шинэ  
боломжийг бий  
болгодог

08

Ажилтан бүр  
борлуулагч,  
харилцагч бүр  
үнэ цэнэтэй

09

Бид юу хийж  
байгаагаа  
хаана хүргэхээ  
үргэлж мэддэг


10

Бид өөдрөг  
уриалгахан  
чин сэтгэлтэй



БИДНИЙ  
БҮТЭЭСЭН ТҮҮХҮҮД...

БАЙГАЛИЙН ЭРДСИЙГ  
ЭС БҮХЭНД ТАНЬ...



## PASION БРЭНД

Цоо шинэ хэв маяг, ялгарлыг өөртөө агуулсан, эрдэсжүүлж, ионжуулсан шүлтлэг усны Pasion брэнд бол Монголын хэрэглэгчдэд маш богино хугацаанд танигдаж чадсан амжилттай төслүүдийн нэг юм. "First Doctor Asia" компанийн эрч хүчтэй, шинийг эрэлхийлэгч хамт олонтой хамтран ажилласнаар "Pasion" брэндийг санаа байхаас нь эхлэн хөгжүүлж хэрэглэгчдийн хүсэмжит, зах зээлд өөрийн орон зайг бий болгосон бүтээгдэхүүн болгон хөгжүүлсэн.

Өрсөлдөөн ихтэй, тоглогч олонтой цэвэр усны зах зээлд бүтээгдэхүүний ялгарлыг бий болгохын тулд бид дотоодын болон дэлхийн зах зээлийн чиг хандлага, зорилтот хэрэглэгчийн хүсэл сонирхол, амьдралын хэв маягт тулгуурлан тус брэндийн концепц, төлөвлөлтийг боловсруулан ажилласан юм.



ALKALINE



BLACK




DETOX



BERRY



GARLIC



## JET INTERNATIONAL SCHOOL

“JET INTERNATIONAL SCHOOL” олон улсын хөтөлбөртэй бүрэн дунд сургууль. Анхны буюу 2019-2020 оны хичээлийн жилд бага, дунд ангид 300 гаран сурагчийг элсүүлж хувийн дунд сургуулиудын хүрээнд түүх бүтээсэн төслүүдийн нэг билээ.

Бидний хувьд ч анхны боловсролын байгууллагын концепц байсан бөгөөд судалгааг үл суурьтай хийж, концепц боловсруулах, брэндийн дүр төрх бүтээх, лого, сурагчийн хувцасны дизайн, идэвхжүүлэлтийн компани ажлын төлөвлөгөөг гаргаж гүйцэтгэх ажлыг амжилттай хамтран хэрэгжүүлсэн юм.





## ХАДАТ ВИЛЛА 2


"ЦОБА" компанийн захиалгаар бид "Хадат Вилла" 2 төслийн судалгаа шинжилгээ, брэндийн концепц, төслийн ерөнхий төлөвлөлт, зураг төслийг хийж хүлээлгэн өгсөн юм.

Брэндартэчүүд бид 2018 оноос эхлэн барилга, дэд бүтцийн төслөөр мэргэшин ажиллаж байгаа бөгөөд 2020 онд бидний хийж гүйцэтгэсэн "Хадат вилла" 2 таун хаус хотхоны концепц, төлөвлөлт нь амины орон сууцны зах зээлд тэсрэлт хийсэн төсөл болж чадлаа.

Бид энэхүү төслийн концепцийг хийхдээ орчин цагийн хүмүүсийн хэрэгцээ шаардлагад илүү ч үгүй, дутуу ч үгүй яв цав нийцэх эдийн засгийн хэмнэлттэй, Монгол орны цаг уурын онцлог, орчин үеийн амьдралын хэв маягт төгс нийцсэн шинэлэг шийдэлтэй, хүнд ээлтэй, байгальд ээлтэй байхаар бодож төлөвлөсөн нь хэрэглэгчийн таашаалыг хүртсэн, эрэлт хэрэгцээтэй сууц болж чадсанд бахархалтай байна.

*Таазны үргэлжлэл тэнгэр байг  
Цонхны минь үргэлжлэл уулсын орой байг  
Шалны минь үргэлжлэл тал байг  
Хязгааргүй бүхэнтэй хамт амьдарна "Хадат вилла" 2*





## БИТУМИНА МОНГОЛИА

Витумина Монголиа бол Монгол орны төдийгүй бүс нутгийн онцгой цаг уурын нөхцөлд тэсвэртэй, ОУ-ын жишигт бүрэн нийцсэн, авто замын бүх төрлийн түүхий эд, материалын цорын ганц үндэсний үйлдвэрлэгч, худалдан борлуулагч, үйлчилгээ үзүүлэгч компани юм.

Бид тус компанийн брэндийн концепц төлөвлөлт, брэндбүүкийг зохион бүтээх, брэнд хөгжүүлэлт, гүйцэтгэлийн ажлууд дээр хамтран ажилласан.





**PREMIUM**  
BUILDING MATERIALS

# ТӨГС БҮТЭЭГЧ 2018

БАРИЛГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ӨГӨӨЖ, ХҮРЭЭЛЭН БҮЙ ОРЧИН



## “ТӨГС БҮТЭЭГЧ” 2020

Бетон зуурмагийн үйлдвэрлэл, үйлчилгээгээр Монголын зах зээлд тэргүүлэгч, үндэсний шилдэг компани "Премиум бьюдинг материалс" ХХК-ийн "Төгс бүтээгч" арга хэмжээг 2018 оноос хойш жил бүр хамтран зохион байгуулж байна. Барилгын салбарын томоохон арга хэмжээнүүдийн нэг болох тус арга хэмжээг 2020 онд цаг үеийн нөхцөл байдал хөл хорионы үе таарсан ч тасалдуулалгүй, "SUSTAINABLE CONSTRUCTION" сэдвийн дор анх удаа дижитал хэлбэрээр зохион байгуулсан юм.

Энэ ажлын хүрээнд гадаадын шилдэг эрдэмтэн судлаач, залуу мэргэжилтнүүдийн 7 цуврал подкаст, 3 видео цуврал контент бэлтгэн M+, Itunes, Soundcloud, Youtube сувгуудаар түгээсэн билээ. Ингэснээр өмнөх жилүүдэд 400 гаруй барилгын салбарын удирдах ажилтнуудад хүрдэг байсан уг арга хэмжээ цар хүрээгээ тэлж барилгын салбарын инженер техникийн ажилчид, оюутан, судлаачид, эцсийн хэрэглэгч гээд 500,000+ хүнд тус салбарын хамгийн шилдэг, үнэ цэнтэй мэдээлүүдийг хүргэж, хэн ч хаанаас ч хүлээн авч үзэж, сонсох боломжтой болсон юм.

# ТӨГС БҮТЭЭГЧ 2019

БАРИЛГЫН САЛБАРЫН ДЭВШИЛТЭТ ТЕХНОЛОГИ, МЕНЕЖМЕНТ



# ТӨГС БҮТЭЭГЧ 2020

SUSTAINABLE CONSTRUCTION







## РЕНДЕР ГРУПП

Төсөөлөөс түлхүүр хүлээлгэх хүртэлх цогц үйлчилгээг үзүүлэгч. Интерьер, экстерьер дизайн, тавилга, хийцийн үйлдвэрлэл, барилгын материал тавилгын худалдаа эрхлэгч, салбартаа тэргүүлэгч Рендер компани.

Бид 2015 оноос хойш тус компанийн маркетингийн стратеги төлөвлөгөөг боловсруулан гүйцэтгэж, шинээр хэрэгжүүлж буй төслүүд дээр нь маркетингийн зөвлөхөөр хамтран ажиллаж байна.






## “ЗӨВ” БРЭНД

“Уламжлалыг шинэчилнэ” уриатай “МИЛКО” компани 2018 онд сүү, цагаан идээний зах зээлд тэсрэлт хийсэн, инновацийн бүтээгдэхүүн болох “ЗӨВ” хатаасан аарц, 2019 онд “ЗӨВ” аарцан үрлийг худалдаанд гаргаж байсан.

Уламжлалт идээ ундааг дотоодын болон дэлхийн зах зээлд гаргах, орчин үеийн хүмүүсийн өдөр тутмын хэрэглээ болгох, аарцны соёлыг түгээн дэлгэрүүлэх энэхүү төсөлд бид хамтран ажилласан юм.

Энэ төслийн хүрээнд Зөв брэндийн концепцийг боловсруулж “Зөвөөр дархлаагаа дэмжье”, “Өдөр бүрийн зөв хэрэглээ”, “Цагаан хувьсгал”, “Эх орны илгээмж” зэрэг компани ажлуудыг хийж гүйцэтгэсэн.





## ХААДЫН ГЭР

Үндэсний гэр урлал, гэрийн тавилга, эсгий эдлэл, гэрийн чимэглэл үйлдвэрлэгч “Хаадын гэр” компани нь зуун хувь гар аргаар урласан, уран нарийн хийц бүхий гэр, гэрийн тансаг тавилга үйлдвэрлэлээр тэргүүлэгч компаниудын нэг юм. Тус компанийн бүтээгдэхүүнийг Монгол төдийгүй дэлхийн зах зээлд таниулах зорилгоор бид 2017 оноос хамтран ажиллаж брэндийн концепцийг шинээр боловсруулах, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлд таниулах идэвхжүүлэлтийн компани ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Брэндийн концепцийг шинэчилж “Хаадын гэр”-ийн тансаг тавилгыг орчин үеийн орон сууцанд нийцүүлэн хөгжүүлж интерьерийн шинэлэг хэв маягийг бүрдүүлснээр бүтээгдэхүүний зах зээлийн багтаамжийг нэмэгдүүлж чадсан юм. Түүнчлэн 2018 онд Монголд анх удаа үндэсний тавилга, уран зураг хосолсон “Домгийн ганц эвэрт” хэмээх контемпорари арт үзэсгэлэнг зохион байгуулж байсан. Өдгөө тус компани Монгол хүний үр ухаан, уламжлалыг шингээсэн орчин үеийн тансаг тавилгуудыг дэлхийн 10 гаруй оронд экспортод гаргаж байна.





**GRAND OPENING**  
ULAANBAATAR, MONGOLIA  
**2017.10.12**



Манай компани тансаг зэрэглэлийн автомашины зах зээлд манлайлагч Английн алдарт Jaguar брэндийн Монгол дахь нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах, зах зээлд шинээр нэвтрүүлэх идэвхжүүлэлтийн компани ажлыг Вагнер Ази Автомотив компанийн захиалгаар амжилттай гүйцэтгэсэн.


Өвөрмөц содон шийдэл бүхий тайз, үзүүлбэр хослуулсан Jaguar-ийн нээлтэд хамгийн олон буюу 600 гаруй зочид цугласны дотор салбар бүрийн олны танил, нэр хүндтэй эрхмүүд багтсан байсан. "Jaguar" брэндийн онцлог давуу талыг зорилот хэрэглэгчийн оюун санаанд хүчтэй байршуулсан идэвхжүүлэлт нь нээлтийн үйл ажиллагаанд хүлээлт үүсгэж чадсан юм.




## ГУРВАН СОР

"Талд төрөөд дэлхийд өрсөлдөнө" уриатай "Гурван Сор" компанийн хамт олон экспортод өрсөлдөх тансаг, дэгжин ноолуурын брэнд бий болгоно гэсэн томхон зорилго өвөрлөн ноолуурын зах зээлд олон шинэлэг бас өвөрмөц загваруудыг гаргасаар ирсэн.

Бид тус хамт олонтой хамтран ажиллаж судалгаа шинжилгээ, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлд өрсөлдөх стратеги, брэндийн концепц боловсруулах, брэндийн дүр төрхийг шинэчлэх, зах зээлд дахин байршуулах идэвхжүүлэлтийн компаниг ажлуудыг хийж гүйцэтгэсэн.





**Kids Us**  
ХҮҮХДИЙН ДЭЛГҮҮР

**Kids Us**  
ХҮҮХДИЙН ДЭЛГҮҮР

## KIDS US ХҮҮХДИЙН ДЭЛГҮҮР

Хүүхдийн хувцасны Kids us брэнд. Хүүхдэд хайртай, хамгийн чанартайг сонгодог тус хамт олны захиалгаар бид брэндийн дүр төрхийг шинэчилж лого, брэндбүүкийн ажлыг хийж гүйцэтгэсэн юм.

Бид Kids Us брэндийн логог зохион бүтээхдээ бүтээгдэхүүний голох түүхий эд хөвөн даавуун утас болон бяцхан үрс бүрийн дуртай амтат модон чихэр, өхөөрдөм дун зэрэг элементүүдийг шингээж яг л хүүхэд шиг хайр татам бас тэднийг баярлуулах хөгжилтэй байхаар бодож хийсэн билээ.



info@kidsus.mn  
kidsus хүүхдийн брэнд хувцас  
www.kidsus.mn

## НҮҮДЭЛЧНИЙ СОЁЛ

“Нүүдэлчний соёл” ХХК нь уламжлалт болон орчин үеийн технологийн төгс нийцэл бүхий алт мөнгөн эдлэл, бэлэг дурсгал, гоёл чимэглэлийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдааны чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, үндэсний гар урлалын шилдэг үйлдвэрлэгч юм.

Бид тус хамт олонтой 2017 оноос хойш “Made with Love” бэлэг дурсгалын сүлжээ дэлгүүрийн концепц, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, зах зээлд таниулах идэвхжүүлэлтийн компаниг ажлууд дээр хамтран ажиллаж ирлээ. Бидний хамтдаа хөгжүүлсэн дээд зэргийн зэвэрдэггүй ган материалтай халуун баригч сав, хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт тритан материалаар хийгдсэн усны сав, мөн монголчуудын уламжлалт гоо зүйн мэдрэмжийг монгол зургийн аргаар өвөрмөцөөр илэрхийлсэн “Эрхэмсэг”, “Оддын зөн” цуврал бүтээгдэхүүнүүд зах зээлд хэдийн танигджээ.

Мөн бид үнэт эдлэлийн зах зээлийн түүхэнд шинэ хуудас нээсэн уламжлалт Монгол дархны мөнгөн утсаар хээ гарган паалангаар өнгө ялган урласан дахин давтагдашгүй мөнгөн аяга, эдлэлийн брэндийг хамтран хөгжүүлээ.





*Инээмсэглэлийг урлана*



## НОМУДА ХОУМ

Монгол хүний хөдөлмөр, ур ухаанаар бүтсэн Монголын анхны хоум фэшн брэнд бол Номуда юм.


“Инээмсэглэлийг урлана” уриатай тус брэндийн концепц, брэндийн дүр төрх, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, маркетингийн стратеги төлөвлөгөөг боловсруулан зах зээлд танилцуулах, идэвхжүүлэлтийн компани ажлыг манай хамт олон хоёр жилийн турш гүйцэтгэж ирсэн.

Өнөөдөр Номуда майхан хүүхэд бүрийн мөрөөдлийн ордон, гэр ахуйн даавуун эдлэлүүд нь эзэгтэй бүрийн хүсэмжит брэнд болж чаджээ.





**BEAU MONDE**  
SKIN CARE & AESTHETIC VIP CLINIC



**BEAU MONDE**  
SKIN CARE & AESTHETIC VIP CLINIC

*Од тэт тог гэрээт*



## BEAU MONDE

Дэвшилтэт технологи, чанар, аюулгүй байдлаар тэргүүлэгч арьс гоо заслын Beau Monde Skin and Aesthetic Clinic. Чадварлаг эмч, мэргэжилтнүүд, дэлхийд тренд болж буй технологи, бүтээгдэхүүнийг эмчилгээндээ нэвтрүүлсэн, хамгийн орчин үеийн арьс гоо заслын VIP эмнэлэг юм.

Тус төслийн концепцийг гаргах, брэндийн дүр төрх, үндсэн мессеж, зах зээлд өрсөлдөх стратегийг боловсруулж гүйцэтгэл дээр нь өнөөдөр ч бид хамтран ажилласаар байна.





*Далд хүсэл,  
Морс мэднэлт*

# SILK


## SILK БРЭНД

Олон улсын эрүүл мэндийн Marie Stopes International байгууллагын захиалгаар Монголд анх удаа дээд зэрэглэлийн бэлгэвч гаргах зэх зээлийн судалгаа, брэндийн концепц төлөвлөлт, сав баглаа боодлын дизайн болон зах зээлд байршуулах идэвхжүүлэлтийн ажлыг цогцоор нь хийж гүйцэтгэсэн.

Судалгаагаар бэлгэвчний худалдан авалтын 90% гаруйг эрэгтэй хүмүүс хийдэг бөгөөд сав баглаа боодлын хувьд шүүд бэлгэвч гэж харагдахгүй байвал таатай байдаг гэсэн үр дүн гарсан. Тиймээс бид Silk брэндийн сав баглаа боодлын дизайныг хийхдээ эрэгтэй буюу хар өнгийг хурц тод өнгөтэй хослуулан сонгож, минимал боловч орчин үеийн байхаар загварчилсан.

Түүнчлэн логоны үсэг тус бүр нь хосуудын дотно харилцааны байрлалыг илэрхийлсэн нь бүтээгдэхүүний нүүрэн дээр бэлгэвч гэж бичээгүй ч ямар зориулалттай бүтээгдэхүүн болохыг илэрхийлсэн, хайрцгаас гадуур сэтгэсэн шийдэл болж чадсан юм.





## БРЭНДАРТЭЧҮҮД

Компанийн үүсгэн байгуулагч Б.Мөнгөнсар нь маркетинг, борлуулалт, брэнд үйлдвэрлэл, бизнес хөгжил, стратеги төлөвлөлт, экспортын чиглэлээр 20 гаруй жилийн мэдлэг, туршлагатай, мэргэшсэн зөвлөх юм.

2015 онд БрэндАртэ компаниа нэг ажилтантайгаар үүсгэн байгуулж байсан бол өнөөдөр 50 гаруй харилцагч байгууллагатай, 10 гаруй ажилтантай, борлуулалтын орлого нь жил бүр өмнөх оныхоос тогтмол 1-2 дахин өссөн, Монголын маркетингийн зөвлөх үйлчилгээний тэргүүлэх компани болж чаджээ. Мөн манай компани Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банкны итгэмжлэгдсэн зөвлөх, Монголын Менежментийн Зөвлөхүүдийн Институт, Америкийн Маркетингийн Холбооны гишүүн юм.

БрэндАртэ компани бизнесийн стратеги, инновацийн зөвлөхүүд, маркетер, дизайнер, эх зохиогч, дижитал артист зэрэг чиглэл бүртээ мэргэшсэн экспертүүд, бүтээлч хүмүүсээр багаа бүрдүүлсэн. Манай мэргэжилтнүүд монголын маркетинг, дизайн, технологи, инновацийн салбарт амжилттай ажиллаж үндэсний болоод олон улсын брэндүүдийг зах зээлд үр дүнтэйгээр байршуулсан туршлагатай.



WORK-PLAY-GROW






# WEEKEND BUSINESS FLIGHT

Амралтын өдрийн бизнес “нислэг”

Хэрэв та:

- Бизнестээ өвөрмөц шинэ санаа, өөр өнцөг хайж байгаа бол..
- Цоо шинэ төсөл эхлүүлэхээр шийдсэн бол ...
- Бизнесийн хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж буй бол..
- Бизнестээ тэлэлт хийж солонгоруулахыг хүсэж байгаа бол..
- Даваа гаригаас өмнө тархины шуурганаас дээгүүр хөөрч өөрийн бизнесийн ертөнцийг өндрөөс тольд...

Тантай хамт “нисэх” манай баг шинэ санаа, бүтээлч сэтгэлгээ, эрч хүчээр дүүрэн, салбар бүрд олон жил ажилласан туршлагатай, хараат бус экспертүүдээс бүрдэнэ. Бид “нислэг”-ийн турш таны бизнесийг огт өөр өнцгөөс харж, зөв оношлон бизнес модель боловсруулах, маркетинг борлуулалт, технологи, бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бизнесийн стратегийн үнэ цэнтэй зөвлөгөөг өгөх болно.

Тархины тань түгжээг тайлж, таны бизнесийн хурдасгуур болох нислэгийн тийзээ яг одоо амжиж захиал. Хамтдаа таны бизнесийн нөхцөл байдлыг эгц дээрээс “дрондъё”



## WEEKEND BUSINESS FLIGHT

